

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН – Хуралдааны тойм

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ХӨТӨЛБӨР № 12

Хуралдаан 2013 оны дөрөвдүгээр сарын 25 -ны өдрийн 14 цаг 15 минутад эхэлж, 15 цаг 30 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 15 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	<p>УИХ-ын Тамгын газрын зарим удирдах албан тушаалд томилуулахаар санал болгосон албан хаагчид Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p> <ul style="list-style-type: none">- Хууль зүйн үйлчилгээ хариуцсан нарийн бичгийн дарга- Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “б”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 4 дүгээр сарын 25ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн үйлчилгээ хариуцсан нарийн бичгийн даргын албан тушаалд Наранчулууны Отгончимэгийг, Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн даргын албан тушаалд Доржзовдын Энхтуяаг тус тус томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатарт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	<p>Соёл, спорт, аялал жуулчлалын яамны зарим удирдах албан тушаалд томилуулахаар санал болгосон албан хаагчид Төрийн албаны зөвлөлийн</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн</p>

	<p>дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p> <ul style="list-style-type: none"> - Төрийн захиргааны удирдлагын газрын дарга - Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга 	<p>жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ын 14-ийн "б"-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 4 дүгээр сарын 25ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Соёл, спорт, аялал жуулчлалын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд Найданпүрэвийн Энхтүвшинг, Соёл, спорт, аялал жуулчлалын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан тушаалд Дуламсүрэнгийн Цэвэлмааг тус тус томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Соёл, спорт, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Алтангэрэлд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	<p>Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны зарим газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай</p> <ul style="list-style-type: none"> - Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга - Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга 	<p>Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Золжаргалын 2013 оны дөрөвдүгээр сарын 17-ны өдрийн 01/1358 тоот тоот албан бичиг, ажлын байрны тодорхойлолтоор Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын, Хүнд үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга Төрийн албаны зөвлөлд ирсний дагуу 2013 оны дөрөвдүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2013 оны тавдугаар сарын 28-29-ний өдөр зохион байгуулахаар шийдвэрлэв.</p>

4	<p>Бусад асуудал: -Комисс томилох тухай</p>	<p>Эрүүл мэндийн яамны дэргэдэх Салбар зөвлөлөөс зохион байгуулсан Эрүүл мэндийн яамны лавлагаа төвүүдийн захирал, дарга нарын сонгон шалгаруулалтын талаар гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх комиссыг гишүүн Д.Даваа-Очир ахалж, УИХ-ын Хуулийн хэлтсийн дарга Ц.Дашдорж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын референт Ганчимэг, Төрийн албаны зөвлөлийн ахлах референт Д.Баатарсайхан, Д.Энхцэцэг, Төрийн албаны зөвлөлийн ССЗҮТ-ийн ажилтан Ш.Эрдэнэбат нарын бүрэлдэхүүнтэй байгуулахаар боллоо. Маргаан хянан шийдвэрлэх комиссын дүгнэлтийг 2013 оны тавдугаар сарын 2-ны өдөр хуралдах Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэлээ.</p>
---	---	--

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ